

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2019.03.25

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<b>1.е.Засгийн газрын тогтоол</b>					
2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	1.1.	Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019.01.10-ны өдөр, Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 3 дугаар тэмдэглэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019.02.13-ны өдөр тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээг тайланг сар, улирлаар гарган, НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд ажлын байранд архидан согтуурсан нэг зөрчлийг илэрснийг шалгаж, байгууллагын ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэн, газрын даргын 2019.02.15-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар ажлаас чөлөөлсөн.	100%	
		Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас		

2	3	4	5	6
1.2.	<p>ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх</p>	<p>ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр хүлээн авч, <a href="http://egr.ulaanbaatar.mn">egr.ulaanbaatar.mn</a> цахим системд бүртгэн, удирдлагад танилцуулж, 10 хоног тутам явцын тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэгдсэн өргөдөл гомдлын хариуг сайтад байршуулан ажиллаж байна.</p> <p>2019 оны 1 дүгээр улирлын байдлаар газрын хэмжээнд нийт 29 өргөдөл ирснийг 100 хувь шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан ба мөн хугацаанд хугацаа хэтэрсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно.</p>	100%	
1.3.	<p>Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах</p>	<p>"Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө", "Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө"-ний дагуу ажлын байранд хяналт шинжилгээ хийж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг 2019 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	70%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
1.4.	<p>Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх</p>	<p>Тус газрын даргаас бусад ажилтан, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан үйлчилгээний албаны ангилалд хамаарах тул уг заалтын биелэлтийн мэдээг гаргах боломжгүй бөгөөд цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p>	Үнэлэх боломжгүй	
	<p>Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах</p>	<p>Манай байгууллага нь төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх</p>		



1	2	3	4	5	6
	1.5.	албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох	үндсэн чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага тул газрын удирдлагаас бусад ажилтан, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан үйлчилгээний албан тушаалд багтдаг. Иймд мөн хуулийн 33 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгдөггүй тул уг заалтыг цаашид хяналтаас хасуулах саналтай байна	Үнэлэх боломжгүй	
	1.6.	Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа 29 ажилтан, албан хаагч, 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж байгаа 1 албан хаагч, эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 3 ажилтан, албан хаагч, нийт 33 ажилтан, албан хаагчтай хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй бөгөөд гэрээт ажилтан ажиллуудаггүй болно.	100%	
	1.7.	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Байгууллагын ёс зүйн журмын 3 болон 4 дүгээр зүйлд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хэрэглэсэн үедээ ирсэн болон ажил үүрэг гүйцэтгэсэн, мөн галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг ажлын байранд нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх,	100%	

	<p>болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох</p>	<p>ашиглахыг хатуу хориглож, ийм үйлдэл гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Ажил олгогчийн санаачилгаар шууд цуцлахаар тусгасан болно. Тайлант хугацаанд ажлын байранд архиван согтуурсан 1 зөрчил гарсныг байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2019.02.14-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэж, газрын даргын 2019.02.15-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар слесарь Ц.Батмөнхийг үүрэг ажлаас нь чөлөөлсөн болно.</p>	
<p>1.8.</p>	<p>Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах</p>	<p>Ажилтан, албан хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийг байгууллагын Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тухай бүр зохих арга хэмжээ авч ажиллалаа. Үүний үр дүнд 2018 оны эхний улиралд 5 ажилтан, албан хаагчид ёс зүйн зөрчил гаргасан бол 2019 оны нэгдүгээр улиралд энэ тоон мэдээ 1 болж, буурсан эерэг үзүүлэлттэй байна.</p>	<p>100%</p>
<p>1.9.</p>	<p>Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах</p>	<p>Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр тогтмол бүртгэж, ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад ногдуулах хариуцлагыг түүнд олгох ур чадварын нэмэгдэлтэй уялдуулан хасч тооцож байна. Уг ажлын хүрээнд ажилтан, албан хаагч бүрийн ажлын цагийн бүртгэлийн тооцоог нэгтгэн гаргаж, 61-240 минут хоцорсон ажилтанд шар өнгийн, 241-480 минут хоцорсон ажилтанд цэнхэр өнгийн, 481-960 минут хоцорсон ажилтанд улаан өнгийн сануулах хуудас хүргүүлэхийн зэрэгцээ мэдээг байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр байршуулж байна.</p>	<p>100%</p>



1	2	3	4	5	6
	<p>Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах</p>	<p>Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Ёс зүйн дүрмийн 3, 4 дүгээр зүйлд ажилтан, албан хаагчид бие биенээ ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа давтан гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан бөгөөд тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил бүртгэгдээгүй болно. Цаашид хамт олны нийтэч, эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байдлыг хадгалахад удирдлагын зүгээс анхаарч ажиллана.</p>	<p>Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Ёс зүйн дүрмийн 3, 4 дүгээр зүйлд ажилтан, албан хаагчид бие биенээ ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа давтан гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан бөгөөд тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил бүртгэгдээгүй болно. Цаашид хамт олны нийтэч, эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байдлыг хадгалахад удирдлагын зүгээс анхаарч ажиллана.</p>	<p>100%</p>	
<p>3.</p>	<p>Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Г.Занданшарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Г.Занданшарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу 2019 оны нэгдүгээр улиралд нийт 4 удаа хяналт шалгалт зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, сайшаалтай талуудыг тэмдэглэн авч, газар дээр нь боломжит байдлаар шийдвэрлэхийн зэрэгцээ зарим асуудлыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаас зөрчил дутагдлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн, богино хугацаанд, чанартай байдлаар шийдвэрлэж, эргэн танилцуулахыг хариуцсан алба, хэлтсийн дарга нарт даалгалаа.</p>	<p>100%</p>	

1	2	3	4	5	6
<p>2018.12.19 № 382 Журам батлан тухай</p>	<p>2.</p>	<p>Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.</p>	<p>Манай байгууллагын ажилтан, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарах үүссэн хөдөлмөрийн харилцааг мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Иймд ажилтан, албан хаагчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, 52 дугаар зүйлийн 52.1, 53 дугаар зүйлийн 53.1, 53.2 дахь заалтыг үндэслэн олгож буй бөгөөд энэ нь газрын даргын 2018 оны А/32 дугаар тушаалаар баталгаажсан болно.</p>	<p>100%</p>	
<p>2019.01.23 № 33</p>	<p>2.</p>	<p>Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.</p>	<p>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, 2019 оны 33 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2018.02.13-ны өдрийн 3 дугаар хурлаар хэлэлцүүлж, газрын даргын 2019 оны А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан болон бусад удирдах албан хаагчид хяналт тавьж ажиллаж буй болно.</p>	<p>100%</p>	
<p>2019.01.30 № 59 2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил</p>	<p>3.</p>	<p>Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас</p>	<p>Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2019 оны 1 дүгээр улиралд дараах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>• НҮГ-т цэвэрлэгээний хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх тухай,</li> </ul>	<p>100%</p>	



болгох тухай”		болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.	<ul style="list-style-type: none"> <li>• НҮГ-ын зоогийн газарт мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх тухай,</li> <li>• НҮГ-ын зоогийн газарт хүнсний бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ бэлтгэн нийлүүлэх тухай,</li> <li>• НҮГ-ын зоогийн газарт хуурай хүнс бэлтгэн нийлүүлэх тухай.</li> </ul> <p>Дээрх худалдан авах ажиллагааны дагуу худалдан авч буй бүтээгдэхүүний 80 хувь нь эх орондоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүн байна.</p>		
---------------	--	---	--	--	--

Хэсгийн дундаж: 97,5 хувь

1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

1	2	3	4	5	6
2019.01.16 № 03-И Монгол улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлангийн талаар	1.	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах	Газрын даргын 2018.12.13-ны өдөр баталсан “Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2018 оны тайлант хугацаанд багтаан <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим сайтad байршуулсан. Дээрх төлөвлөгөөний хүрээнд 2019 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлсэн “НҮГ-т цэвэрлэгээний хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх тухай”, “НҮГ-ын зоогийн газарт мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх тухай”, “НҮГ-ын зоогийн газарт хүнсний бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ бэлтгэн нийлүүлэх тухай”, “НҮГ-ын зоогийн газарт хуурай хүнс бэлтгэн нийлүүлэх тухай” тендерийн мэдээллийг тухай бүр <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим сайтad байршуулан ил тод байдлыг эрхэмлэн ажиллаж байна.	100%	
2		Төрийн болон орон нутгийн	Тайлант хугацаанд дараах журам, стандартад	100%	

	4	Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх	Тайлант хугацаанд ажлын байранд архидан согтуурсан 1 зөрчлийг байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2019.02.14-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэж, газрын даргын 2019.02.15-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар слесарь Ц.Батмөнхийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн болно.	100%	
	5.	Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан мэдээ, газрын хэмжээнд хэрэгжиж буй дүрэм журам, заавар стандартыг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна. Харин манай байгууллага нь төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага тул аливаа тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.	100%	
	6.	Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллаж	Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох тайлагнах журам"-ын дагуу "Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г батлуулж, үүнд нийцүүлэн алба хэлтэс, ажилтан, албан хаагчдын ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнд мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ажилтан, албан хаагчдын ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2019.03.25-ны өдрийн	70%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй



		Дотор хүлээн авч байна.			
7.	Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох	НИТХ-ын Тэргүүлэгчдээс 2019 оныг "Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан манай байгууллага нь 2019 оныг "Байгууллагын хөгжил – Үйлчилгээний чанарын жил" болгон зарлаж, үндсэн 3 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилтот ажлын хүрээнд хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, тогтвор суурьшлыг хангах үүднээс ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэн, үзүүлж буй үйлчилгээг боловсронгуй болгох, улмаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдад үзүүлж буй үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэн, чанарыг сайжруулах талаар үе шаттай ажлууд хэрэгжүүлж байна.	100%		
8	Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх	Нийтлэг үйлчилгээний газрын "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 2018-2020 оны төлөвлөгөө", "2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө"-ний хүрээнд 2019.03.20-ны өдөр "Мэдээллийн цаг"-ийг зохион байгуулсан, Мэдээллийн цагаар НОБГ-ын Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Чинбат гамшгийн үед аюул ослоос өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт мэдээлэл өгсөн ба сургалтад манай байгууллагын 220 ажилтан, албан хаагч оролцсон.	100%		
9.	Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн	Төрийн албан хаагчидтай шууд харилцдаг үйлчилгээний болон инженер техникийн ажилтан, албан хаагчдын ажлын чанар, ёс зүйг үнэлж	70%		Хэрэгжилт тооцох хугацаа

		үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох	дүгнэх зорилгоор "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлээд байна.		болоогүй
<p>2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай</p>	1.	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх</p>	<p>Энэхүү заалт нь манай байгууллагын чиг үүрэгт хамааралгүй байх тул биелэлт гаргах боломжгүй юм.</p>	Үнэлэх боломжгүй	
	1.2.	<p>Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур Л.Уранхайчийн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд Нийслэлийн засаг захиргааны 5А байрны менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгааны инженер З.Эрдэнэбаяр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул түүний оронд цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инженерээр тус тус дэвшүүлэн ажиллаж байна.</p>	<p>Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон ажиллаж, Үйлчилгээний албаны дарга Л.Уранхайчийн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд Нийслэлийн засаг захиргааны 5А байрны менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгааны инженер З.Эрдэнэбаяр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул түүний оронд цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инженерээр тус тус дэвшүүлэн ажиллаж байна.</p>	100%	
	1.3.	<p>Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаал түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан</p>	<p>Энэхүү заалт нь манай байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй байх тул биелэлт гаргах боломжгүй юм.</p>	Үнэлэх боломжгүй	



		<p>тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас чөлөөлж дүнг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх</p>	3	4	5	6
1	2	<p>Төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж, хууль тогтоомж зөрчдөг үйлдлийг таслан зогсоох, ийм гэрээт ажилтны гэрээг цуцалж, уг орон тоог хуульд заасан журмын дагуу нөхөх</p>	4	<p>Манай байгууллагын нийт ажилтан, албан хаагчид нь Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг тул уг заалтын хэрэгжилтийн талаар мэдээ, тайлан гаргах боломжгүй юм.</p>	5	6
1.4				<p>Манай байгууллагын нийт ажилтан, албан хаагчид нь Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг тул уг заалтын хэрэгжилтийн талаар мэдээ, тайлан гаргах боломжгүй юм.</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>	
1.5		<p>Төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>		<p>Ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон, актлах хугацаа болсон хөрөнгийг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, Өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрээр акталсан тохиолдолд тэдгээрийг шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>70%</p>	<p>Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй</p>
1.6.		<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар</p>		<p>Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа, сургалт мэдээллийн цаг, оролцсон арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр зурагжуулан баримтжуулж, холбогдох мэдээллийн хамт <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> сайтад байршуулан, ил</p>	<p>100%</p>	

	хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	тод байдлыг ханган ажиллаж байна.		
1.7.	Төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах	"Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө"-ний дагуу хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтныг 2019 оны хоёрдугаар улиралд багтаан мэргэшүүлэх сургалтад хамруулна.	70%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
1.8.	Төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах	"Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 2018-2020 оны төлөвлөгөө"-ний хүрээнд "Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө"-г боловсруулж, 2019.02.04-ний өдөр газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	
1.9.	Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх	Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнд мэргэшлийн түвшинг үнэлэх журам", байгууллагын "Ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, үр чадварын нэмэгдэл олгох журам"-д нийцүүлэн үнэлж, цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хуульд тогтоомжид нийцүүлэн олгож байна.	100%	
1.10.	Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт шинжилгээ хийж үр дүнг албан	"Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г бодлогын болон захирамжлалын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, 2019.03.15-ны өдөр газрын даргаар батлуулсан. Уламжлалын дагуу төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт	70%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй



		<p>удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх</p>	<p>шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрийн дотоод журам,</li> <li>• Байгууллагын ёс зүйн дүрэм,</li> <li>• Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам,</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага,</li> <li>• Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага,</li> <li>• Хоол, цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага,</li> <li>• Ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, ур чадварын нэмэгдэл олгох журам,</li> <li>• Байгууллагын архивын дүрэм,</li> <li>• Албан хэрэг хөтлөлтийн архивын ажлын зохион байгуулалтын журам,</li> <li>• Хэвлэмэл хуудас хүчингүй болгох журам.</li> </ul> <p>Түүнчлэн байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай дараах журмыг шинээр боловсруулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажлын хувцас, хэрэгсэл ашиглалтын журам,</li> <li>• Ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам,</li> <li>• Хөдөлмөрийн аварга шалгаруулах журам</li> </ul>		
	3	<p>Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх</p>	<p>2019 оны 1 дүгээр улиралд ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн 29 өргөдлийг шуурхай шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид цахим системээр, утсаар болон биечлэн өгсөн. Тайлант хугацаанд гаргасан зөрчилгүй, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоногтой байна.</p>	100%	

		хаагчдад тогтмол мэдээлж байх	шинжилгээ хийж, тайлан мэдээг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд илгээж, энэ талаарх мэдээллийг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулж ажиллана.		
1	2	3	4	5	6
	1.11.	Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож, иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, хэвшүүлэх	Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, хариуцлагын зохицуулалтыг шинээр болон шинэчлэн баталсан хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан. Энэхүү ажлын үр дүнд сахилга хариуцлагыг чангатгаж, хариуцсан ажил үүргээ цаг тухайд нь чанартай гүйцэтгэдэг ажилтан, албан хаагчийг төлөвшүүлнэ. Түүнчлэн 2019 оны хоёрдугаар улиралд “Соёлтой үйлчилгээ” болзолт уралдааныг инженер техникийн болон үйлчилгээний ажиллагсдын дунд зохион байгуулахаар төлөвлөөд байна.	100%	
2019.01.23 № 05-XX.I Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлангийн тухай	-	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчаас ирүүлсэн 29 өргөдлийг шуурхай шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид цахим системээр, утсаар болон биеллэн өгсөн. Мөн хугацаанд гаргасан зөрчилгүй, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоногтой байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдээгүй үзүүлэлттэй байна.	100%	
Хэсгийн дундаж: 91,66 хувь					
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл					
1	2	3	4	5	6



	1.	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу мэдэгдэх	Тайланг хугацаанд ажилтан, албан хаагчдаас 29 өргөдөл хүсэлт ирсэнийг бүрэн шийдвэрлэж хариуг цахим системээр, утсаар болон биечлэн өгсөн. Өргөдөл гомдлыг богино хугацаанд хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэхэд тогтмол анхааран ажиллаж буй бөгөөд шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн гомдол санал гараагүй болно.	100%	
2019.01.10 № 02-1 Өргөдөл гомдлын шийдвэрлэлти йн 2018 оны жилийн эцсийн тайлангийн тухай	2.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулж, хандалт их өргөдөл, гомдлын шалтгаан нехцөлийг судлан, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн иргэдээс гаргасан саналыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн байдлыг тайлан мэдээнд тусгайлан оруулах	2019 оны нэгдүгээр улиралд ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн 29 өргөдөл хүсэлтийг ажлын 4 хоногт багтаан шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 32 өргөдлөөр буурсан байх ба шийдвэрлэлтийн дундаж хугацаа нэмэгдээгүй зэрэг үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой тайлан мэдээг НЗДТГ-ын 2019.03.04-ний өдрийн 03/764 дүгээр албан бичгээр ирсэн зөвлөмжийн дагуу боловсруулж байна.	90%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
	3.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд "UB ERP" дотоод удирдлагын систем ашиглах болсонтой холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтантай уулзах иргэдийн хүсэлтийг дээрх системээр бүртгэн, шийдвэрлэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын	Ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр "UB ERP" дотоод удирдлагын системээр бүртгэж, уг системээр дамжуулан холбогдох албан тушаалтанд илгээж, хариуг системд бүртгэж байна. Түүнчлэн egr.uiaanbaatar.mn дотоод удирдлагын системээр дамжуулан төрийн албан хаагчдын санал, хүсэлтийг тухай бүр хүлээн авах, сэтгэл ханамжийн судалгаа авдаг болох зорилгоор хамтран ажиллах саналыг Мэдээлэл технологийн газарт хүргүүлээд байна.	100%	